

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛ ХЭЛТСИЙН 2022 ОНД ХИЙСЭН АЖЛЫН БИЧМЭЛ ТАЙЛАН

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн багц хууль, Улсын Их хурлын тогтоол, Хууль зүйн сайдын тушаал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын тушаал болон бусад эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласнаар тайлант хугацааныхаа зорилт, төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, ил тод байдлыг сайжруулах, шинэ төрлийн үйлчилгээг үзүүлэх, Аймаг орон нутгийн удирдлагтай хамтран ажиллаж дэвшүүлэн тавьсан зорилтуудаа биелүүлж зохих үр дүнд хүрсэн болно.

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг Хэлтсийн дарга-1, Хяналтын улсын байцаагч-1, Улсын ахлах бүртгэгч-2, Улсын бүртгэгч-7, сумдын Улсын бүртгэгч -25, төрийн үйлчилгээний-5, жирэмсэн амаржсаны чөлөөтэй-3, Гэрээт ажилтан-1 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Бүртгэлийн ажилтан, албан хаагчдын 2022 оны зорилт бол

- ✓ Бүртгэлийн үйлчилгээг иргэд, аж ахуй нэгжид хөнгөн шуурхай хүргэх
- ✓ Мэдээллийг цахим санд тухай бүр оруулах
- ✓ Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах
- ✓ Бүртгэлийг ямар нэгэн зөрчил дутагдалгүй хийх
- ✓ Сумдынхаа Улсын бүртгэгч нараар дамжуулан бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх,
- ✓ Бүртгэлийн үйлчилгээг иргэдэд сурталчлах
- ✓ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дахин, нөхөн сонгуулийг амжилттай зохион байгуулах
- ✓ Улсын бүртгэгчид болон сумдын Улсын бүртгэгч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

1. Дотоод ажил, зохион байгуулалтын хүрээнд:

Завхан аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасаг нь 3 улсын бүртгэгч, 1 ахлах бүртгэгчтэй бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. 24 сумын иргэний улсын бүртгэлийн чиглэлээр бүртгэгдсэн бүртгэлийг хүлээн авч хянан мэдээллийн санд баталгаажуулж байна. Мөн сумын улсын бүртгэгч нарыг мэдээ мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. 2022 онд ажиллах ажил үүргийн хуваарь болон цахимжуулах дарааллыг гарган хүргүүлээд ажиллаж байна. 2022 оны 04 сарын 26,27 өдөр тоон гарын үсгийн сургалтыг зохион байгуулсан. Тоон гарын үсгийг 2022 оны 05 сарын 01 эхлэн иргэдэд олгож эхлээд байна. Орон нутгийн нөхөн сонгуулийн сургалтуудад төлөвлөгөөний дагуу хамрагдаж сонгуулийг амжилттай зохион байгуулсан. ГХБХБГазар, Отгон сумын засаг даргын тамгийн газартай хамтран Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан.

2. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2.1 Нийт хөтөлсөн бүртгэл

Иргэний улсын бүртгэлийн чиглээр эхний 11 сарын байдлаар нийт **5993** бүртгэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс: төрөлт 1050, үрчлэлт 16, овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр

өөрчилсний бүртгэл 54, эцэг, эх тогтоосны бүртгэл 63, гэрлэлтийн бүртгэл 210, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 29, нас баралтын бүртгэл 350, шилжилт хөдөлгөөний бүртгэл 839 иргэний үнэмлэхийн бүртгэл 2776 гадаад паспортын 570 регистрийн дугаар өөрчилсний бүртгэл 9, бүртгэл тус тус бүртгэгдсэн байна. Бүртгэсэн ИУБ-маягтуудыг галиглан А талыг нэгдсэн архивын газар болон иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллаж байна. Нийт 10354 хуудас цахимжуулсан.

Бусад аймаг, нийслэлээс шилжин ирсэн иргэдийн хувийн хэргийг нэхэмжлэн хүлээн авч, байгууллагын архивт хүлээлгэн өгч байна.

2.2 Олгосон лавлагааны тоо

Иргэнд 2400 лавлагаа албан хэрэгцээнд 1490, вэб 6, албан тоотоор 553 лавлагааг өгч ажилласан байна.

2.3 Нийт иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн албан бичиг: 2022 оны 11-р сарын байдлаар нийт 31 албан бичгийг ИУБГ-т хүргүүлсэн.

2.4 Хүлээн авсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт: 2022 оны байдлаар нийт 4 дүгнэлтийг хүлээн авч регистрийн дугаар сольсон байна.

2.5 Шүүхийн шийдвэрээр 6 иргэн регистрийн дугаар сольсон байна.

2.6 Иргэний бүртгэлтэй холбоотойгоор гарсан 65 дүгнэлтийг цахимжуулсан.

Газрын даргын өгсөн шуурхай үүрэг даалгаварын биелэлт:

Иргэний бүртгэлийн газрын даргын 2022 оны 4/2584 тоот албан бичгийг хүлээн авч нийт улсын бүртгэгч нарт шуурхай танилцуулж ажиллалаа. Бүртгэлүүдийг шалган тайланг тогтоосон хугацаанд хүргүүлж 1067 иргэний бүртгэлийг засварласан. Үүнээс 0-16 насны 800, гэрлэлтийн төлөв засах 267 иргэний холбогдох материалыг цахимжуулж Иргэний бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан.

3. Иргэний өргөдөл, санал хүсэлт шийдвэрлэлтийн талаар:

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу олгосон гэх 3 иргэний өргөдлийг хүлээн авч нотлох баримтыг үндэслэн регистрийн дугаарын өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэсэн.

4. Бусад чиглэлээр:

Сумдад аман болон бичгэн хэлбэрээр зөвлөмж хүргүүлсэн байдал:

Нийт улсын бүртгэгч нарт иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа хэрхэн олгох талаар мэдээлэл, зөвлөмж өгч ажиллалаа. Сар бүрийн ажлын сүүлийн өдөр нийт улсын бүртгэгч нарт тухайн сард бүртгэгдсэн бүртгэлийн эх нотлох баримтуудыг хянан зөрчлийг танилцуулж цаашид анхаарах асуудлуудын талаар цахимаар тогтмол зөвлөмж өгч ажиллалаа.

УБЕГ-аас ирсэн чиглэл, зөвлөмжийг тухай бүр улсын бүртгэгч нарт утсаар болон цахимаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

5. Жилийн онцлох ажил:

Байгууллагын архиваас 2005-2010 оны хойш төрсөн иргэдийн төрөлтийн ХААТР маягтуудыг татан авч мэдээллийн санд тулган шалган ургийн овгийн зөрчилтэй болон төрөлтийн бүртгэл санд тусгагдаагүй иргэдийн бүртгэлийг 800 иргэнийг ИУБГ-т хүргүүлж зөрчлийг арилгуулж ажилласан.


Гэрлэлтийн төлөв өөрлөгдсөн 267 иргэний мэдээллийг хүргүүлэн төлөвийг засан ажилласан байна.

Тоон гарын үсгийг 61 байгууллага аж ахуй нэгжийн ажилтан албан хаагчидад ажлын байран дээр нь олгох ажлыг зохион байгуулсан.

6. Байгууллагын нээлттэй байдлыг хангасан байдал

Байгууллагын вэб сайт болон байгууллагын мэдээллийн самбарт тухайн сард бүртгэсэн бүртгэлийн тоон мэдээ болон бусад мэдээллүүдийг байршууллаа. Байгууллагын пэйж хуудсаар иргэний бүртгэлтэй холбоотой асуулт ирүүлсэн 8 иргэнд мэдээлэл өгч ажиллалаа.

7.Дээрх бүртгэлүүдийг графикаар өмнөх онуудтай харьцуулж харуулбал



Үрчлэлт, эцэг тогтоолт, овог нэр өөрчлөлт



Шилжилт хөдөлгөөн



ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ТАЙЛАН

Хэлтсийн Эд Хөрөнгийн Эрхийн Улсын Бүртгэлийн тасаг нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлийн тухай хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор гарсан заавар журмуудыг үндэслэн Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хөнгөн шуурхай хүргэж ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн Тасгийн энэ оны гол зорилго бол Байгууллагын стандартыг хэрэгжүүлэх, бүртгэлийн үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд аль болох түргэн шуурхай үйлчлэх зорилт тавин үйлчилгээний хугацааг богиносгох, бүртгэлийн нотлох баримтуудыг сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан хүлээн авах, ил тод байдлыг хангахад чиглэгдэж байсан болно.


Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь Улсын ахлах бүртгэгч 1, Улсын бүртгэгч 4, Архивч 1, гэрээ ажилтан 1 гэсэн ажиллах хүчний нөөцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Нэг.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар

Тайлант хугацаанд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийт 3922 мэдүүлэг хүлээн авч эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийг хийсэн.

Нийт мэдүүлгийн:

- 313-г Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл
 - 46-г Шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэл
 - 341-г Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл
 - 2643-г Гэрээ хэлцлийн бүртгэл
 - 29-г Лавлагааны бүртгэл
 - 550-г Бусад бүртгэл тус тус эзэлж байна.
- Үүнийг хувиар нь харуулвал



Нийт бүртгэсэн гэрээ хэлцлийн:

- 580-г Худалдах худалдан авах гэрээ
- 53-г Бэлэглэх гэрээ
- 66-г Хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл
- 97-г өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдсөн бүртгэл
- 556-г Барьцаалбаргүй барьцааныгэрээ
- 241-г Барьцаалбартай барьцааны гэрээ
- 864-г Барьцааныгэрээдуусгаварболгох
- 186-г бусад гэрээ хэлцлийн бүртгэлтус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд нийт 1820 гэрчилгээ бичиж олгосноос 817 газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн, 1003 газар өмчлөх эрхийн гэрчилгээ тус тус бичигдсэн байна. Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын дагуу байгууллагад үйлчилгээний хураамжаас 37156322 сая төгрөг, орон нутгийн төсөвд тэмдэгтийн хураамжаас 2149776 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны албан татвараас 193089032 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Хууль хяналтын байгууллагаас ирсэн 205 тоотын 356 иргэний лавлагаа мэдээллийг үнэ төлбөргүй гарган өгч ажилласан.

Тайлант хугацаанд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 359 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн 341 хувийн хэрэг шинээр нээж, 7 хувийн хэрэг хааж, 3215 хувийн хэрэгт

холбогдох баяжилт үйлчилгээг хийсэн. Тус хэлтсийн эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн архивт 12 сарын 02 ны байдлаар 21133 хувийн хэрэг хадгалагдаж байгаа ба газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 8549, Газар өмчлөх эрхийн 7297, Газар эзэмших эрхийн 5287 хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.

Бүртгүүлэхээр орж ирсэн 3922 мэдүүлгийг цахим мэдээлийн сан болох Electronic Property Registration System (ePRS)-т шивж оруулсан бөгөөд 3215 хувийн хэрэгт үйлчилгээ хийж нотлох баримтыг нэмж оруулж, холбогдох журнал дэвтрүүдийг цаг тухайд нь хөтөлсөн. Архивт хадгалагдаж байгаа хувийн хэргийг цаасан болон цахим мэдээллийн сантай тулгах тооллого одоогийн байдлаар газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 8393, газрын 6105, нийт 14498 хувийн хэргийг тулгасан байна. Хувийн хэрэг буюу 22221 үйлчилгээтэй 556250 хуудас бүхий баримтыг тоолж тулгалт хийх ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

ХЯНАЛТЫН АЖИЛ

Хяналтын үйл ажиллагааг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Улсын бүртгэлийн хяналтын дүрэм, Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд явуулж байна. Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

2022 онд Иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах хяналтын улсын байцаагчийн 65 дүгнэлт гарган, 801 бүртгэлд хяналт тавьж 14 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгасан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн 3 дүгнэлт гарган, 65 бүртгэлд хяналт тавин 2 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгасан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн 45 дүгнэлт гарган, 519 бүртгэлд хяналт тавьж 4 зөрчлийг илрүүлэн арилгасан.

Хяналтын улсын байцаагч улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 703 бүртгэлд цахимаар хяналт тавин, зөрчилтэй 5 бүртгэлийг хүчингүй болгонж зөрчлийг арилгаж, хяналтын улсын байцаагчийн албан шаардлага бичиж 7 бүртгэлийн зөрчлийг арилгасан.

2022 онд Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 27, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 4 өргөдөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл 3, зөрчлийн талаарх гомдол мэдээллийн 271, нийт 305 өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан зөрчилд улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр заасны дагуу 271 иргэнээс ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авч бүртгэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 5420000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.

Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн бүртгэлийг 11 удаа, зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 22 удаа аймгийн Прокурорын газарт хянуулан ажиллаж, аймгийн Прокурорын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2022 оны хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 3 удаа шалгуулсан.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Монгол улсын иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан эрхийн актуудын биелэлтийг хангаж ажиллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шинээр батлагдсан хууль, журмыг сурталчлах иргэд, хуулийн этгээдүүдийн удирдлагуудад таниулах зорилт тавьж ажиллаж байна.

Хоёр: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар

Хуулийн этгээд шинээр байгуулах хүсэлт ирүүлсэн 394 иргэний хүсэлтийг хүлээн авч нэрийн давхардлыг нэрийн баазаас шалган баталгаажуулан. Материалыг хууль журманд нийцэж байгаа эсэхийг шалган шаардлага хангасан материалыг хүлээн авч тухай бүр нь 224 хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэж улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон байна. Хуулийн этгээдийн хэлбэрийн өөрчлөх хүсэлт ирүүлсэн 7 хуулийн этгээдийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөн улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 381-г нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг Улсын бүртгэлд бүртгэж эрх олгосон. Салбар төлөөлөгчийн газар шинээр байгуулах хүсэлт ирүүлсэн 31 хуулийн этгээдийн салбарыг бүртгэж улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон байна. Салбарын өөрчлөлт бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 1 салбарын өөрчлөлтийг бүртгэж эрх олгосон. Дахин гэрчилгээ авах материал ирүүлсэн 38 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон байна. Улаанбаатар хот руу шилжих материал ирүүлсэн 4 хуулийн этгээдийг шилжүүлэн хувийн хэргийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт хүргүүлсэн. Татан буулгах хүсэлт ирүүлсэн 6 хуулийн этгээдийг хүсэлтийн дагуу татан буулгаж улсын бүртгэлээс хасч хувийн хэргийг архивт хүргүүлсэн байна. Хууль хяналтын байгууллагууд болон хуулийн этгээдүүдээс ирүүлсэн 18 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн архиваас лавлага, мэдээлэл авах хүсэлт ирүүлсэн 176 иргэнд лавлагаа мэдээлэл олгосон.

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

Завхан дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах зорилгоор олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна. “Завхан аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудас нь 2202 like, 2000 дагагчтай байгаа бол <http://zavkhan.burtgel.gov.mn/> веб хуудас нь нийт 5000 хэрэглэгчдийн хандалт авсан байна. <http://zavkhan.burtgel.gov.mn/> веб хуудсанд нийт 165 мэдээ мэдээлийг нийтэлсэн. Санхүүгийн ил тод байдлын талаар 11 Хурал, сургалт, семинар, хэлэлцүүлгийн талаар 13 Жил, улирлын тайлан 2 Нээлттэй ажлын байрны зар 0 Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдалаар 5 Сар бүрийн статистик тоон мэдээ 11 Түгээмэл асуулт хариулт 18 Цаг үеийн мэдээ /хэлтэс, орон нутагтай холбоотой мэдээ тэмээлэл/ 165 Видео мэдээ /хэлтэс, орон нутагтай холбоотой мэдээ тэмээлэл/ 13 “Завхан аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд нийт шторк, хэвлэн олшруулж байршуулах материал, инфографик зэргээр нийт 250 мэдээ мэдээллийг нийтэлсэн. Мөн хэлтсийн үйлчилгээний заалны Үнэмлэх, гэрчилгээг хүндэтгэлтэй, ёслол төгөлдөр гардуулах, дурсгалын зураг авхуулах фонн бүхий буланг Нэг цэгийн үйлчилгээний танхимд хийсэн байна.

Мөн иргэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх үүднээс E-mongolia өөртөө үйлчилэх буланг байгуулгаж, Улсыг бүртгэлийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл

боломж бүрдүүлэн ажиллаж байна.Тус буланг хийснээр 900 гаруй иргэн лавлагаа үйлчилгээ авсан байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.Мөн УБЕГ-ын Мэдээллийн технологийн газараас өгсөн SOPHES рүүтерийг солиж тохиргоо хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй тухай бүрт нь засварлаж нийт 6 удаагийн эвдрэл гэмтэл гарсныг хэвийн ажиллагаанд оруулж засварласан байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь тэмдэглэл хөтлөн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал, болон сургалтууд 33 орчим удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Завхан аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь сумдын улсын бүртгэгч нартайгаа цахим видео хурал болон сургалтыг 12 удаа амжилттай зохион байгуулсан байна.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдахаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулах тохиргоог хийж ажилласан.

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВ

2022 онд Иргэний улсын бүртгэлийн тасгийн архивын үйл ажиллагаа хууль тогтоомжинд нийцсэн лавлагаа мэдээллээр хурдан шуурхай үйлчилж, архивын материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эмх цэгцтэй байршуулан баяжилт хийж хууль дүрэм журмын дагуу тогтмол тасралтгүй явагдсан.

Дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт болон хариутай бичгийг цаг хугацаанд нь гаргаж байна. Цагдаагийн газар, Завхан аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Завхан аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба, Төрийн банкны Завхан дахь салбар, Прокурорын газар, Тосонцэнгэл сумын сум дундын шүүх, Аймгийн архивын тасаг зэрэг байгууллагуудын 102 албан тоотын дагуу 223 иргэний лавлагаа өгч үйлчилсэн байна.

Завхан аймгийн тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тоотын дагуу 436 иргэний хувийн хэрэг материалыг татан шалгаж холбогдох ХААТР маягтыг хуулбарлан хүргүүлсэн.

Хоёр1. Архивын сан болон цахим сан бүрдүүлэлтийн талаар:

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр шинээр бүртгэл хийгдсэн 4123 ширхэг ИУБ маягтыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулан баяжилт хийсэн.

Мэдээллийн санд зөрчилтэй 250 иргэний хувийн хэргийг татан шалгаж холбогдох ХААТР маягтыг хуулбарлан мэдээллийн санд зөрчилийг арилгасан.

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВ

Тайлант хугацаанд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 494 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн 322 хувийн хэрэг шинээр нээгдсэн 1024 хувийн хэрэгт холбогдох баяжилт үйлчилгээг хийж улсын бүртгэгчдээс гарсан нотлох баримтуудыг бүртгэлийн дэвтэрт бүртгэж нь хувийн хэрэгт тухай бүрт нь байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 5954 баяжилт үйлчилгээг хувийн хэрэгт байршуулан улсын бүртгэгч бүрээр нь бүртгэлийн А-2 маяганд тэмдэглэл хөтлөн архивт байршуулан ажиллаа. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 8236 газраас бусад үл хөдлөх хөрөнгийн, 3597 газрын, эзэмших эрхийн э дугаарын бүртгэл 2604 нийт 18880 хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВ

Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн архивын 142 хувийн хэргийг шинээр нээсэн Улсын бүртгэгчээс маягтын дагуу хүлээн авч архивт байршуулсан. Тайлант хугацаанд 362 нэмэлт өөрчлөлт орсонг хувийн хэргийг архивт байршууллаа. Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа 674, албан бичгийн хариугаар хууль хяналтын байгууллагад 20 лавлагаа, Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн архивт 2399 хувийн хэрэг хадгалагдаж байна.

АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Тайлант хугацаанд хэлтсийн бичиг хэргийн үйл ажиллагаанд холбогдох стандартыг хэрэгжүүлэх, хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь өгөх, төр засгийн шийдвэрийн биелэлтэнд картаар хяналт тавих, бичиг хэрэгтэй холбоотой мэдээ тайланг хугацаанд нь хүргэх, бичиг хэргийн соёлыг улам дээшлүүлэхэд чиглэгдэж байсан. Улсын бүртгэл ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар баталсан хадгалах хугацааны жагсаалтын дагуу Баримт бичиг нягтлан шалгах комиссын дарга болон гишүүдтэй хамтран ББНШК-ын хурлыг хуралдуулж ХХНЖ-ийг шинэчлэн, байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, Түр хадгалах хадгалах нэгжийн бүртгэл гэж 3 ангилан боловсруулсан.

Тайлант хугацаанд 910 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж, 1100 албан бичгийг бусад байгууллагуудаас хүлээн авч бүртгэн, ABLE програм болон төрийн байгууллагын цахим шуудан буюу /mail.gov.mn/ хаягаар мэдээ тайлангаа явуулж, дотоод албан бичгээ хүлээн авч 540 хариутай бичигт хяналтын карт хөтлөн албан бичгийн хариуг хугацаанд нь холбогдох газарт нь албан тоотоор болон webmail хаягаар хүргүүлсэн.

2022 оны жилийн эцсийн байдлаар Хяналтын Улсын байцаагчийн дүгнэлттэй холбоотой 44 бусад-17 өргөдөл, нийт 61 өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэсэн. Иймд өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100% шийдэгдсэн байна.

Нярав: Тайлант хугацаанд сумдын Улсын бүртгэгчид болон албан хаагчидад олгосон үнэт цаас, хаатр маягт, бичиг хэргийн материалуудыг зохих журмын дагуу шаардах хуудас бичүүлж, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтөлж, өгсөн үнэт цаасны хатуу дугаарыг иргэний улсын бүртгэлийн онлайн программд хуваарилан ажиллаж байна. Мөн гэрчилгээ, маягт, хил орчмын нутагт зорчих үнэмлэхийн зарцуулалтын тайлан, тоон мэдээг сарын бүрийн 05-ны өдрийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүү аж ахуйн газарт хүргүүлсэн.

ТӨСӨВ САНХҮҮ

Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хуулиуд, төр засгийн шийдвэрүүдийн хүрээнд явуулж ирсэн. Хэлтсийн санхүү аж ахуйн 2022 оны гол зорилт:

1. Төсвийг ил тод нээлттэй болгох, Төсвийн гүйцэтгэлийн мэдээг холбогдох газруудад хүргүүлэх, Санхүүгийн тайлан балансыг улирал бүр гарган нэгтгүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үнэт цаас болон бараа материалын тайланг сар бүр батлагдсан маягтын дагуу гаргаж явуулах

2. Хэлтсийн албан хаагчид болон Сумдын улсын бүртгэгч нарын ажиллах ая тухтай нөхцлийг хангах зэрэгт чиглэгдсэн болно.

Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хэлтсийн 2021 оны Санхүүгийн тайланд Аймгийн Аудитын байгууллагаар гүйцэтгэлийн аудит хийлгэн **“Зөрчилгүй”** дүгнэлт авч Улсын бүртгэлийн ерөнхий газарт тайлангаа тушаан, Аудитын байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа УСНББОУС-ыг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийг батлагдсан төсвийн дагуу үр ашигтай захиран зарцуулж байна.

Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж Шилэн дансны Вэб сайт, цахим хуудас болон ил тод байдлын самбарт 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан, сар бүрийн батлагдсан хуваарь, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг тухай бүр нь байршуулсан. Үнэт цаасны зарцуулалт, татан авалт, нөөцөнд хяналт тавин, няравын үлдэгдлийг хагас жилээр тооллого хийн гэрчилгээ, хаатр маягт зарцуулалтын тайлантай тулган баталгаажуулсан. Сар бүр үнэт цаасны мэдээтэй тулган холбогдох Улсын бүртгэгч нараас орлогын мэдээ авч баримтыг журналуудтай тулгаж байгаа нь зөвхөн үнэт цаасанд хяналт тавиад зогсохгүй ажлын хариуцлагыг сайжруулсан, оновчтой ажил болсон. Ингэснээр Улсын төсөв болон орон нутагт төвлөрүүлж байгаа орлого үнэн зөв мэдээлэгдэж мэдээ тайлан цаг алдалгүй бодитойгоор гарч байна.

Хүчингүй болсон үнэт цаасыг УБЕГ-ын даргын 2021 оны А/707, А/706 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу төлүүлэх, актлах саналыг Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үнэдэслэн акталж данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллаж байна. Тайлант хугацаанд Улсын төсөвт 117.0 сая, орон нутагт 104 сая төгрөг төвлөрүүлсэн.

Тайлант хугацаанд Улсын төсвөөс нийт 638.5 сая төгрөгийн санхүүжилт авч цалин, НДШ-ийн зардалд 576.9 сая, Бусад бараа үйлчилгээний зардалд 61.6 сая төгрөгийг тус тус батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна. Мөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн зардалд 9.2 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсвийн дагуу зарцуулсан. Хэлтсийн 2021 оны санхүүгийн баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.

ТАЙЛАН БИЧСЭН: ДАРГА

Ж.СҮХБААТАР